БАТЛАВ: НАРАН СУМЫН ЗАСАГ
ДАРГА Л.ОЧ

# СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН ТӨВИЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ,СПОРТ ТОГЛООМЫН ТАЛБАЙ, ӨЛЗИЙТ БУЛАГИЙГ ТОХИЖУУЛАХ АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2023.04.27 Дугаар:017/ЗД-2023 Баруун-Урт

| | | |
|---|---|---|
| 1 | Зураг төсөл боловсруулах үндэслэл: | - Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br>- Сүхбаатар аймгийн Наран сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 06 тоот тогтоол |
| 2 | Барилга байгууламжийн байршил: | Сүхбаатар аймгийн Наран сумын 1,3-р баг |
| 3 | Захиалагч байгууллага: | Сүхбаатар аймгийн Наран Засаг даргын тамгын газар |
| 4 | Ерөнхий төлөвлөгөө,зураг төсөл боловсруулахад ашиглах материал: | Норм нормативууд:<br>• Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм дүрэм /БНбД30-01-04/<br>• Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/<br>• Гэрэлтүүлэг чимэглэлийн ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг /БНБД 83-27-00/<br>• Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулах сандалд тавигдах шаардлага /UCS 1404C:2020/<br>• Саравч, сүүдрэвчинд тавигдах ерөнхий шаардлага / UCS 1201C B:2020/<br>• Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байршуулах хогийн саванд тавиглах шаардлага /UCS 1403C:2020/<br>• Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм<br>Бусад холбогдох норм дүрэм |
| 5 | Технологийн шийдэл: | Барилгын зураг төсөл боловсруулах, норм дүрэм болон одоогоор мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэд шийдлүүдийг сонгох |
| 6 | Гүйцэтгэх ажлууд: | Гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсаны дараа тухай барилгын захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөж |

| | | |
|---|---|---|
| | | нэмэлт санал авна.<br><br>Тухайн гэрэлтүүлэг хашааг барих байршлыг газар дээр нь ирж үзэж танилцаж ажлыг хийж гүйцэтгэнэ.<br><br>Үүнд:<br><br>**Сумын төвийн гэрэлтүүлэг**<br>• Сумын төвд шинээр хийгдэх гудамжны гэрэлтүүлгийн цахилгааны кабель шугам татах, галын аюулгүй байдлыг хангах.<br>• Шинээр хийх гэрэлтүүлгүүдийг сонгохдоо өнгө үзэмж сайтай орчин үеийн гэрэл төлөвлөх.<br>• Гэрэлтүүлгүүдийн суурийг чанарын өндөр түвшинд хийх. / Гэрэлтүүлэгийн утасыг газар доогуур байхаар төлөвлөх/<br>• Гэрэлтүүлгийн шонгийн газардуулгын ажил норм дүрмийн дагуу хийгдсэн байх.<br>• Гудамжны гэрэлтүүлгийн холболт, угсралтын ажил хийхдээ технологийн дагуу хийх.<br>• Цахилгаан байгууламжийн стандарт, ерөнхий шаардлагыг дагаж мөрдлөг болгон ажиллах.<br>• Сумын төвийн гудамж эгнээнд 100 вт-н 30 ширхэг гэрэлтүүлэг, 3 цамхаг гэрэл тус бүртээ 8 ширхэг гэрэлтэй байхаар төлөвлөх<br>• Гэрэлтүүлэг явган хүний замруу давхар туссан байх<br>• Цамхаг гэрэлтүүлэг нь автомат цагын тохируулгатай релифтэй байх.<br><br>**Спортын тоглоомын талбай**<br><br>• Спорт тоглоомын талбайд 100 вт-ын 4 ширхэг гэрэлтүүлэг төлөвлөх.<br>• Спорт тоглоомын талбайн хашааг засварлаж, шаардлагатай хэсгийг шинээр хийж угсрах.<br>• Спортын тоглоомын талбайг иж бүрэн цементэн тэгшилгээ өнгөлгөө хийж, стандарт норм дүрмийн дагуу гүйцэтгэх<br>• Спорт тоглоомын талбайн нэг талд 3х3 сагсан бөмбөгийн талбай 2 ширхэг байхаар стандарт нормын дагуу төлөвлөх, эсрэг талд хүүхдийн тоглоомын талбай байршуулахаар сонгон төлөвлөх<br>• Спортын тоглоомын төрөл элементүүдийг оруулан төлөвлөх / резинэн хавтантай байх/<br>• Тоглоомын талбайд сандал, суудал, сүүдрэвч хог хаягдал сав зэрэг орчин үеийн өнгө үзэмж сайтай төлөвлөх |